



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/13

Батноров сум

Өмчлөлийн газрын хэмжээ өөрчлөх
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дахь заалт, Монгол улсын Хаягжуулалтын тухай хуулийн 4.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах тухай" журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2009 оноос геодезийн байрлал, өндрийн нэгдсэн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор туузан метрээр хэмжиж тодорхойлсон, кадастрын зурагт тэмдэглэгдсэн байршил, газрын талбайн хэмжээ нь нарийвчилсан хэмжилтээр зөрүүтэй гарах тохиолдлууд гарч байгаатай холбогдуулан Дундбүрд багийн Булаг гудамжны 214 тоот хаягт байрлах 2.164.400 (Хоёр сая нэг зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун) төгрөгийн үнэ бүхий гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 1546 квадрат метр газрыг Цэсрэн овогтой Баярмаад өмчлүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Батноров сумын Засаг даргын 2017 оны А/136 дугаар захирамжийн 58 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгч Ц.Баярмаад өмчилсөн газрын хил заагийг газар дээр нь тэмдэгжүүлж хүлээлгэн өгөх, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОТГОНБАЯР

230425068